

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2016.09.22.

Дугаар № /

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид төв гэх) түүнийг төлөөлж ЭМХТ-ийн захирал Ч.Бат-Эрдэнэ, негеэ талаас “Эмзүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо” ТББ (цаашид холбоо гэх) түүнийг төлөөлж тэргүүн 3.Зузаан нар дараах нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Талууд Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ын зорилтын хэрэгжүүлэхэд хамтран ажиллах харилцааг зохицуулна.
- 1.2 Гэрээний хэрэгжилтийг хангахад дараах зорилгын хүрээнд талуудын саналыг тусган удирдамж хөтөлбөрийг тухай бүрт боловсруулж ажиллана.

Хоёр. Зорилго

Эмийн чанар, аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнүүд, эрүүл мэндийн байгууллага, эм хангамжийн байгууллага болон ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх, улмаар эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн, мэдээлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, олон улсын стандарт, туршлагыг үйл ажиллагаандaa нэвтрүүлэн хамтран ажиллахад энэхүү гэрээний зорилго оршино.

Гурав. Хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- 3.1 Эмийн аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд иргэд, эмнэлгийн мэргэжилтэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоо, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;
- 3.2 Эмийн бүртгэлийн дараах тандалт судалгаа явуулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмийн зохистой хэрэглээний судалгааны ажилд хамтрах;
- 3.3 Эмийн бодлого зохицуулалтын үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйг дээшлүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэх, холбогдох байгууллага, олон улсын байгууллагын туршлагыг судлах, нэвтрүүлэх;

- 3.4 Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, эмийн бүртгэл, эмийн чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх гарын авлага боловсруулж, хэвлэж, түгээхэд хамтран ажиллах;

Дөрөв. Ажлын төлбөр тооцооны талаар

- 4.1 Талууд харилцан тохиролцсоны дагуу үйл ажиллагаанд шаардагдах зардал 3800000 (гурван сая найман зуун мянган) төгрөгийг Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбооны Худалдаа хөгжлийн банкин дах 499213930 тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Семинарт оролцсон тухай тайланг 3 хоногт багтаан ирүүлнэ.
5.2 Талууд гэрээний хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавина.
5.3 Аль нэг тал хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар үнэн зөв мэдээлэл өгнө.

Зургаа. Гэрээг баталгаажуулах, дүгнэх

- 6.1 Гэрээ нь 2 талын төлөөлөл гарын үсэг зурж баталгаажсанаар хүчин төгөлдөр болно.
6.2 Гэрээний биелэлт болон гүйцэтгэлийг үнэлж, дүгнэнэ.
6.3 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол харилцан тохиролцож болно.
6.4 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэнэ.

Хамтран ажиллах гэрээ байгуулсан :

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

Ч.БАТ-ЭРДЭНЭ

Гарын үсэг.....



УХА0456 9086331

“ЭМ ЗҮЙН
ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО” ТББ-ЫН
ТЭРГҮҮН

ЗЭУЗААН ЭЖЛЭЭР
ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО
НҮТББ

Гарын үсэг.....

TT37971 № 8109869

МЭРГЭЖЛЭЭР
ТӨГСӨГЧДИЙН ХОЛБОО” ТББ-ЫН